



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2012 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай" хуулийн 17 дугаар зүйл, тус газрын Хөдөлмөрийн дотоод журмын 8.9.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Зочилох үйлчилгээний салбар өндөр хөгжсөн орнуудад мөрдөгдөж байгаа олон улсын болон дотоодын стандартуудыг Улаанбаатар хотын зочид буудлуудад танилцуулах сургалтыг 2012 оны 04 сарын 23,24-ний өдрүүдэд зохион байгуулахыг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /Д.Ганболд/, гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /Г.Гансүвд/ нарт үүрэг болгосугай.

Хоёр. Сургалт зохион байгуулахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

Гурав. Сургалт зохион байгуулахад шаардагдах 2.560.000 /Хоёр сая таван зуун жаран мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Сургалт зохион байгуулсан тухай илтгэх хуудсыг 04 сард багтаан танилцуулахыг мэргэжилтэн үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /Д.Ганболд/, гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн /Г.Гансүвд/ нарт үүрэг даалгасугай.

ДАРГА



Ш.СҮХБААТАР

11525300016



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2026 оны 04 сарын 18 өдрийн
тушаалын хавсралт

УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛЖ БУЙ ЗОЧИД
БУУДЛУУДАД ЯПОН УЛСЫН ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРТ МӨРДӨГӨЖ
БАЙГАА СТАНДАРТЫГ ТАНИЛЦУУЛАХ СУРГАЛТЫН УДИРДАМЖ

д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /₮/	Нийт зардал /₮/
1	Япон улсын зочилох үйлчилгээний салбарт мөрдөшдөж байгаа олон улсын болон дотоодын стандартуудыг орчуулах зардал	90 хуудас	15.000	1.350.000
2	Сургалтын танхимын түрээс	2 өдөр	240.000	480.000
3	Тараах материал	40 багц	9000	360.000
4	Цайны завсарлага	40*2	200	160.000
5	Бичиг хэрэг, хувилах олшруулах	-	-	210.000
	Бүгд төсөв			2.560.000

ТӨСӨВ ЗОХИОСОН:

МЭРГЭЖИЛТЭН

Д.ГАНБОЛД
Г.ГАНСУВД

ХЯНАСАН:

НЯГТЛАН БОДОГЧ:

П.АРИУНАА